



САНГИЙН ЯАМ

# ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ НАРЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ УДИРДАМЖ

[Төсвийн тухай хуулиас:  
8.3.4.санхүү, төсвийн  
асуудал эрхэлсэн төрийн  
захиргааны төв  
байгууллага Засгийн  
газрын баталсан жилийн  
төсвийн хязгаарыг  
төсвийн удирдамжийн  
хамт жил бүрийн 7 дугаар  
сарын 5-ны дотор  
төсвийн ерөнхийлөн  
захирагчид хүргүүлэх]

[Төсвийн удирдамж болон  
төсөв бэлтгэх маягууд,  
судалгааны хүснэгтүүд MS  
Word болон MS Excel файл  
хэлбэрээр Сангийн яамны  
веб хуудсанд тавигдсан  
болно]

[Холбоос линк](#)

# АГУУЛГА

1.	ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (ТЕЗ) НАРЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР .....	3
2.	ТЕЗ НАРЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЗААВАР .....	3
2.1	Өмнөх жилийн удирдамжаас өөрчлөгдсөн зүйлс: .....	3
2.2	Төсвийн урсгал зардлын талаар .....	4
2.3	Орон нутгийн төсвийн орлогын талаар .....	8
2.4	Орон нутгийн төсвийн зарлагын талаар.....	9
2.5	Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал бэлтгэх.....	10
2.6	Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний санал бэлтгэх .....	12
2.7	Төсвийн саналыг FISCAL-B программд оруулах .....	13
2.8	Төсвийн ангиллыг ашиглах .....	14
2.9	Төсвийн санал хүлээн авч хянах.....	14
3.	ТӨСВИЙН САНАЛЫН МАЯГТ БӨГЛӨХ ЗААВАР .....	15
3.1	Төсвийн үндсэн маягт буюу ТМ-01.....	15
3.2	Төсвийн үндсэн маягтын нэмэлт буюу ТМ-01а.....	17
3.3	Төсвийн удирдамжид дагалдсан төсвийн маягтуудын товчоо .....	18
3.4	Бусад .....	19

## **1. ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ (ТЕЗ) НАРЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ХЯЗГААР**

Төсвийн тухай хуулийн 4.1.8-д “жилийн төсвийн хязгаар гэж төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дэд хэмжээг”, 8.3.3-т “Засгийн газар төсвийн ерөнхийлөн захирагчийн жилийн төсвийн хязгаарын төслийг хэлэлцэн жил бүрийн 7 дугаар сарын 01-ний дотор батлах” гэж заасан.

Улсын Их Хурлаас 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдөр баталсан Монгол Улсын нэгдсэн төсвийн 2024 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2026 оны төсвийн төсөөллийн тухай хуулиар 2024 оны нэгдсэн төсвийн тэнцвэржүүлсэн нийт орлогыг ДНБ-ий 32.3 хувь, нийт зарлагыг ДНБ-ий 35.1 хувь, нэгдсэн төсвийн нийт тэнцвэржүүлсэн алдагдлыг ДНБ-ий 2.8 хувь байхаар тус тус тогтоосонтой нийцүүлж Засгийн газрын 2023 оны 6 дугаар сарын 21-ний өдрийн 245 дугаар тогтоолоор “Төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн хязгаар”-ыг баталсан. *(Улсын төсөв, нийгмийн даатгалын болон эрүүл мэндийн даатгалын сангийн төсвийн хязгаарыг Сангийн сайдын албан бичгийн 2 дугаар хавсралтаас үзнэ үү)*

## **2. ТЕЗ НАРЫН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ БЭЛТГЭХ ЗААВАР**

### **2.1 Өмнөх жилийн удирдамжаас өөрчлөгдсөн зүйлс:**

2.1.1. Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагч нарын 2024 оны төсвийн орлогын саналыг онлайнд суурилсан FISCAL-B системээр хүлээн авна. *(Удирдамжийн 2.7-ийг харах)*

2.1.2. Төсвийн зардлын чиг хандлагыг дунд хугацаагаар (нэг ба түүнээс дээш жилээр) болон хөгжлийн бодлогын баримт бичигт дурдсан зорилт, хүрэх үр дүнд суурилан төлөвлөх үйл явц, салбарын чадавхыг сайжруулах зорилгоор боловсрол болон эрүүл мэндийн салбарын 2024 оны төсвийн төсөлд ашиглах маягт, заавар шинээр нэмэгдсэн. *(Удирдамжийн 2.2.3-ийг харах)*

2.1.3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам, Соёлын яам болон Биеийн тамир спортын улсын хороонд туршиж байгаа Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн маягт, зааварчилгаа шинэчлэгдсэн. *(Удирдамжийн 2.2.5-ийг харах)*

2.1.4. Дорноговь аймгийн сонгогдсон хөтөлбөрийн хүрээнд туршиж байгаа Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн төсвийн

төлөвлөлтийн маягт, зааварчилгаа шинэчлэгдсэн. (Удирдамжийн 2.2.5-ийг харах)

- 2.1.5. Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийг шинээр нэмж Эрүүл мэндийн яаманд турших бөгөөд улсын төсвийн бүх ерөнхийлөн захирагч нараас ирүүлэх маягт, нэмэлт зааварчилгааг шинэчлэн оруулсан. (Удирдамжийн 2.2.7-ыг харах)

## 2.2 Төсвийн урсгал зардлын талаар

- 2.2.1 Төрийн хэмнэлтийн тухай хуулиар төсвийн байгууллага, түүний албан тушаалтны зарим үйл ажиллагаа, хангамжийг хязгаарласантай холбогдуулан төсвийн урсгал зардлын саналд хуулиар хориглосон зардал, арга хэмжээг тусгахгүй байх;
- 2.2.2 Төсвийн урсгал зардлын төлөвлөлтийг **1.2\_Төсвийн саналын маягт.xlsx**-ын дагуу бэлтгэх (Бүх ТЕЗ нар *нарийвчилсан зааварчилгааг энэхүү удирдамжийн 3.1 дахь хэсгээс харах*);
- 2.2.3 Төсвийн хөтөлбөрийн хүрэх үр дүн болон шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо **1.3\_TM-01a маягт бөглөх заавар** дагуу бэлтгэн ирүүлэх;
- 2.2.4 Эрүүл мэнд болон боловсрол, шинжлэх ухааны салбарт туршиж байгаа үр дүнд суурилсан дунд хугацааны төсөвлөлтийн хувьд **2.1\_ҮДСДХТ төсвийн саналын маягт.xlsx**- маягтыг **2.2\_ҮДСДХТ Маягтын заавар.doc** зааврын дагуу боловсруулж ирүүлэх. Боловсрол шинжлэх ухааны салбарын үр дүн шалгуур үзүүлэлтийг тодорхойлохдоо **1.4\_TX3 үр дүн тодорхойлох заавар (БШУЯ)** ашиглан бэлтгэх. Холбогдох тодруулгыг Сангийн яамны ТБТГ-ын Нэгтгэлийн хэлтсийн зөвлөх Т.Биндэръяа (binderiya\_t@mof.gov.mn, 267350)-аас авах.
- 2.2.5 Тогтвортой хөгжлийн зорилгод нийцсэн төсөвлөлтийг туршиж байгаа ХХААХҮЯ, ХНХЯ, СЯ, БТСУХ-ууд **6.1\_ҮДСТ Төсвийн саналын маягт\_УТ.xlsx** болон **6.2\_ҮДСТ Төсвийн саналын маягтын заавар\_УТ.docx** маягтын дагуу бэлтгэх. Дорноговь аймгийн хувьд **6.3\_ҮДСТ Төсвийн саналын маягт\_ОН.xlsx** болон **6.4\_ҮДСТ Төсвийн саналын маягтын заавар\_ОН.docx** маягтын дагуу бэлтгэж тодруулгыг доор дурдсан холбогдох зөвлөхүүдээс лавлана уу. Үүнд:
- ХНХЯам-ны нийгмийн халамж болон хөдөлмөр эрхлэлтийг дэмжих хөтөлбөртэй холбогдох тодруулгыг зөвлөх У.Чулуунцэцэгээс [chuluuntsetseg.ulambayar@undp.org](mailto:chuluuntsetseg.ulambayar@undp.org),

86095545 болон хүүхдийн хөгжил хамгаалалтай холбогдох тодруулгыг Ж.Ганбаатар [ganbaatar3848@gmail.com](mailto:ganbaatar3848@gmail.com), 99123848, У.Сүхдарь, [suheedari@gmail.com](mailto:suheedari@gmail.com), 9922 8288 нараас лавлана уу.

- ХХААХҮЯамны сонгогдсон хөтөлбөртэй холбогдох тодруулгыг зөвлөх С.Оюунсоёмбо [oyunsoyombo.s@gmail.com](mailto:oyunsoyombo.s@gmail.com), 98210479, Б.Ариунаа [ariunaab2019@gmail.com](mailto:ariunaab2019@gmail.com), 99101347 лавлана уу.
- Соёлын Яамны сонгогдсон хөтөлбөртэй холбогдох тодруулгыг зөвлөх Ж.Ганбаатар 99123848 [ganbaatar3848@gmail.com](mailto:ganbaatar3848@gmail.com), Б.Сэргэлэн [sergelen.ut@gmail.com](mailto:sergelen.ut@gmail.com) 99144521 нараас лавлана уу.
- Биеийн тамир спортын улсын хорооны сонгогдсон хөтөлбөртэй холбогдох тодруулгыг зөвлөх Г.Амаржаргал, [mcmara0816@gmail.com](mailto:mcmara0816@gmail.com), 86002323 лавлана уу.
- Дорноговь аймгийн сонгогдсон хөтөлбөрийн холбогдох тодруулгыг зөвлөх Г.Сувд [g.suvd2018@gmail.com](mailto:g.suvd2018@gmail.com), 88115129 лавлана уу.

Түүнчлэн ТХЗ-той уялдсан үр дүнд суурилсан төсөвлөлтийн маягтын дагуу төсөв боловсруулж байгаа бүх түвшний төсвийн захирагч нар ҮДСТ-ийн маягтыг бүрэн зөв боловсруулж байгаа эсэхийг **6.5\_ҮДСТ Төсвийн шалгах хуудас** дагуу шалгаж ирүүлэх.

## 2.2.6 Цалин хөлс болон төрийн албан хаагчид олгох тэтгэмж, урамшуулал

2.2.6.1 Төрийн албан хаагчийн Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж (213207), хуульд заасны дагуу зарим салбарт олгодог Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг (213208)-ийг 2023 оны IV улирлаас эхлэн Сангийн яамны “Төрийн албаны цалингийн нэгдсэн систем” (ТАЦНС)-д тооцоолон, албан хаагчийн арилжааны банкны дансанд шууд шилжүүлэн олгохоор системийн хөгжүүлэлт хийгдэж байна. Төрийн албаны зөвлөлийн “Хүний нөөцийн удирдлага мэдээллийн тогтолцоо” (ХНУМТ) цахим системийн “Ажилтан” цэсийн “Ажил эрхлэлт – Ажил эрхлэлтийн түүх” хавтсанд 2024 онд өндөр насны тэтгэвэрт гарах болон хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг авах албан хаагчийн ажлын туршлага (төрийн болон хувийн хэвшилд ямар албан тушаал хашиж байсан), ажилласан хугацаа (жил, сар, өдөр)-ны мэдээллийг нягталж, холбогдох баяжуулалт хийнэ.

Мэдээллийн баяжуулалтыг байгууллагын хүний нөөцийн асуудал хариуцсан ажилтан 2023 оны 8 дугаар сарын 15-ны дотор хийсэн байна.

ХНУМТ цахим системд мэдээллийн баяжуулалт хийхтэй холбоотой асуудлыг ТАЗ-ийн 265042 утсаар болон <https://www.facebook.com/CSCHRSYSTEM> хуудасны чат хэсгээс тодруулна уу.

Төрийн албанд ажилласан жилийн мэдээллийг оруулахдаа Засгийн газрын 2019 оны 7 дугаар тогтоолын хавсралтаар баталсан “Төрийн албан хаагчид өндөр насны тэтгэвэрт гарахад нэг удаагийн буцалтгүй тусламж олгох журам”-д заасныг баримтална.

2.2.6.2 Төсвийн төлөвлөлт, төсвийн тодотгол, цалин хөлсний зардлын таамаглал, цалин хөлстэй холбоотой удирдлагын түвшний шийдвэр гаргалтад ТАЦНС-д тооцоологдсон албан хаагчдын цалин хөлсний өгөгдлийг ашиглана. Тиймээс төсвийн байгууллагууд ТАЗ-ийн ХНУМТ цахим систем дэх албан хаагчдын цалингийн сүлжээний ангилал, зэрэглэл, шатлал, үндсэн цалингийн хэмжээ, нэмэгдлийн хувь хэмжээ, албан хаагчийн үндсэн мэдээлэл үнэн зөв эсэхэд хяналт тавьж, мэдээлэлд өөрчлөлт орох, албан хаагч нэмэгдэх, хасагдах, шилжих зэрэг өөрчлөлтийг тухай бүр системд нэн даруй оруулж ТАЦНС-д мэдээллийг шинэчилж татна уу. Цаашид, ТАЦНС-ийн өгөгдлийг Сангийн яамны төсвийн төлөвлөлтийн Fiscal.B системтэй холбон цалин хөлсний төсөвлөлтийг хийхээр төлөвлөж байна.

2.2.6.3 Төсвийн төлөвлөлтийн Fiscal.B системд төсвийн байгууллага бүрийн орон тооны мэдээллийг цалингийн сүлжээгээр шивж оруулна. Энэ нь Төсвийн төлөвлөлтийн Fiscal.B систем дэх хянасан орон тоо | батлагдсан орон тоо болон ТАЦНС-д албан хаагчдын цалин хөлсийг тооцож олгосон орон тооны өгөгдлийг ашиглан ТАЦНС-д “Орон тооны харьцуулсан тайлан” гаргахад ашиглагдах юм. Ингэснээр, бүх шатны төсвийн мэргэжилтнүүд сар бүрийн орон тоо, цалин хөлсний мэдээлэлд хяналт хийх боломжтой болно.

2.2.7 **Жендерийн мэдрэмжтэй төсөвлөлт (ЖМТ):** Монгол Улсын Засгийн газар холбогдох хууль тогтоомж, салбар дундын жендерийн эрх тэгш байдлыг хангах 10 жилийн стратеги төлөвлөгөө, салбарын яамдын жендерийн бодлогуудад тусгагдсан ЖМТ-ийн аргачлалыг төсвийн шинэчлэлийн нэг хэсэг болгон ЖМТ-ийг зарим сонгосон яамдад 2021 оноос туршиж эхэлсэн.

Энэхүү аргачлалыг боловсрол, хөдөлмөр эрхлэлт, нийгмийн хамгааллын салбарын сонгосон хөтөлбөрүүдэд туршиж, 2023 оноос эхлэн шинээр эрүүл мэндийн салбарыг нэмж хамруулахаар төлөвлөөд байна. Цаашид бусад салбар, хөтөлбөрүүдийг ЖМТ-д үе шаттай хамруулах, чадавх бэхжүүлэх хөтөлбөрийг тасралтгүй хэрэгжүүлэх, төсөвлөлтийн аргачлалыг боловсронгуй болгох, төсвийн процесст шаардлагатай өөрчлөлтийг хийх, холбогдох эрх зүйн орчныг бүрдүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг өргөжүүлэх зэргээр ЖМТ-г үндэсний түвшинд бүрэн нэвтрүүлэх зорилт тавьж байна.

ЖМТ нь төрийн үйлчилгээний хүртээмж, чанарыг сайжруулахад чиглэсэн аажмаар явагдах үйл явц байх юм. Иймд ТЕЗ нараас дараах байдлаар санал авахаар төлөвлөж байна. Үүнд:

**а/** ЖМТ-ийг туршин нэвтрүүлж байгаа БШУЯ, ХНХЯ, шинээр ЭМЯ-ны сонгосон хөтөлбөр, арга хэмжээний саналуудыг **5\_ЖМТ асуулга ба төсвийн саналын маягт.xlsx** хавсралтад заасан ЖМТ-ТМ-03 маягтыг ашиглаж бэлтгэнэ.

**б/** Жендерийн мэдрэмжтэй бодлого төлөвлөлт болон төсөвлөлтийг улсын бүх ТЕЗ нар төсвийн зарцуулалтыг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнах талаар өдөр тутмын ажлын нэг хэсэг болгохын тулд улсын салбаруудын чадавх болон туршлагыг үнэлж, бодит нөхцөл байдлыг тодруулах үүднээс улсын бүх ТЕЗ нараас **5\_ЖМТ асуулга ба төсвийн саналын маягт.xlsx** хавсралтад заасан ЖМТ-НМ-01, ЖМТ-НМ-02 асуулга болон судалгааг бүрэн бөглөх; Холбогдох тодруулгыг Сангийн яамны ТБТГ-ын төслийн зөвлөх Э.Эрдэнэцэцэг-тэй 51-265753 дугаараар эсвэл ([erdenetsetseg\\_e@mof.gov.mn](mailto:erdenetsetseg_e@mof.gov.mn)) цахим шуудангаар холбогдож лавлана уу.

2.2.8 Бүх ТЕЗ нар өөрсдийн хэрэгжүүлж байгаа хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүнг тодорхойлж, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг **1.1\_Төсвийн саналын маягт.xlsx** файл дахь “**ТМ-01а**” маягт ашиглан тодорхойлох. Маягт бөглөх зааврыг удирдамжийн хавсралт **1.3\_ТМ-01а маягт бөглөх заавар.docx** файлаас үзэх.

Холбогдох тодруулгыг Сангийн яамны ТБТГ-ын төслийн зөвлөх Т.Биндэръяа - аас [binderiya\\_t@mof.gov.mn](mailto:binderiya_t@mof.gov.mn), 51-267350 лавлана уу.

## 2.3 Орон нутгийн төсвийн орлогын талаар

Орон нутгийн 2024 оны төсвийн орлогын төсөөллийг боловсруулахад төсвийн болон татварын хууль тогтоомжийг мөрдөж, Засгийн газрын зорилтуудыг биелүүлэхэд шаардлагатай санхүүгийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд ач холбогдол өгч ажиллах бөгөөд суурь орлого, санхүүгийн дэмжлэг, дээд шатны төсөвт татан төвлөрүүлэх орлогын хэмжээг зохистой тогтоох үүднээс Аймаг, нийслэлийн Засаг дарга дараах шаардлагыг хангасан мэдээллийг ирүүлнэ. Үүнд:

- 2.3.1 Төсвийн орлогын эдийн засгийн ангиллын дагуу орон нутгийн орлогын төсөөлөл, гүйцэтгэл, холбогдох тайлбар танилцуулга бэлтгэх;
- 2.3.2 Төсвийн тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6.10 дахь заалтад заасны дагуу 2024 онд орон нутгийн төсөвт төвлөрөх аж ахуйн нэгжийн орлогын албан татварын төсөөлөл, судалгааг бэлтгэж ирүүлэх боловсруулах;
- 2.3.3 Ирэх 2024 онд орон нутагт хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа томоохон төсөл хөтөлбөрийн мэдээлэл, холбогдох танилцуулгыг ирүүлэх. Хэрэгжүүлэх томоохон төсөл хөтөлбөрийг Засгийн газар, орон нутгийн түвшинд хэрхэн дэмжих, эрх зүйн орчныг сайжруулах талаар санал бэлтгэх;
- 2.3.4 Орон нутагт үйл ажиллагаа явуулж буй уул уурхайн компаниудын үйл ажиллагааны мэдээлэл, үйлдвэрлэл борлуулалтын төсөөллийн талаар мэдээлэл бэлтгэх;
- 2.3.5 Ирэх 2024 онд доод шатны төсвөөс дээд шатны төсөвт төвлөрүүлэх орлогын тооцооллын нарийвчлан тооцох зорилгоор сум, дүүргийн 2020-2023 онуудын төсвийн орлогын судалгааг Төсвийн тухай хуулийн 23.8, 23.9 дэх хэсэгт заасан татварын болон татварын бус орлогын ангиллаар **4\_Сум, дүүргийн суурь орлого, суурь зарлага.xlsx** файл дахь хүснэгтийг ашиглан гаргаж ирүүлэх
- 2.3.6 Улсын Их Хурал, Засгийн газар төрийн өмчит болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдийн ил тод байдал, үйл ажиллагааг сайжруулах чиглэлээр тодорхой чиглэл өгсөнтэй холбогдуулан орон нутгийн өмчит хуулийн этгээдийн төсөвт төвлөрүүлэх ногдол ашгийн орлогын тооцоо хийх;
- 2.3.7 Хувь хүний орлогын албан татварын төсөөллийг боловсруулахад Нийгмийн даатгалын байгууллагын цалин, хөдөлмөрийн хөлс болон түүнтэй адилтгах орлогын албан татвар төлөгч иргэдийн мэдээллийг татварын мэдээллийн баазтай тулгаж, хөдөлмөр эрхлэгчдийн тоо, цалингийн сан, ажилласан хугацаа зэргийн



гүйцэтгэлийг 2023 оны хагас жилийн болон өнгөрсөн 2022 оны жилийн эцсийн байдлаар [3\\_ОН төсвийн орлогын тооцоолол.xlsx](#) файл дахь 5.ХХОАТ болон дагалдах хүснэгтүүдийг ашиглан цалингийн интервалаар бэлтгэн ирүүлэх;

- 2.3.8 Газрын төлбөр, хөрөнгийн албан татварын орлогын төсөөллийг хийхэд орон нутгийн газрын алба, бүртгэлийн байгууллагаас шаардлагатай мэдээллийг авах, нэгтгэн боловсруулах;
- 2.3.9 Хог хаягдлын тухай хууль болон Сангийн сайд, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2018 оны 192, А/243 дугаар тушаалаар хамтран баталсан “Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлал”-ын дагуу нэгдсэн журмаар тооцож ирүүлэх;
- 2.3.10 Шинээр батлагдсан хууль тогтоомж, төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөө үзүүлэх үр дагавар бүхий шийдвэрийн нөлөөллийг тооцож, холбогдох мэдээлэл материалыг хавсаргаж ирүүлэх (Иргэдийн хурлын тогтоол г.м);
- 2.3.11 Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар тогтоосон албан татварын хувь, хэмжээний мэдээллийг холбогдох тогтоол, шийдвэрийн мэдээллийн хамт ирүүлэх;
- 2.3.12 Орон нутгийн төсвийн төсөөлөл, орон нутгийн орлогын гүйцэтгэлийг сайжруулах чиглэлээр хууль тогтоомж, дүрэм, журамд оруулах өөрчлөлтийн санал бэлтгэн ирүүлэх.
- 2.3.13 Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тооцооллыг Засгийн газрын 2022 оны 1 дүгээр сарын 5-ны өдрийн 2 дугаар тогтоолоор батлагдсан “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журмын 8 дугаар хавсралтад заасан “Байгаль орчныг хамгаалах арга хэмжээний төсөв, зардлын мэдээллийн сан”-ийн БНАТ-5 маягтын “Ус, рашааны нөөц ашигласны төлбөрийн орлого”, “Газрын нөөцийн төлбөрийн орлого”, “Байгалийн ургамлын нөөц ашигласны төлбөрийн орлого”, “Ан амьтны нөөц ашигласны төлбөрийн орлого”, “Ойн нөөц ашигласны төлбөрийн орлого”-ын 2024 оны төлөвлөгөөтэй нийцүүлэх. Ирэх оны төлөвлөгөөг 2023 оны 7 дугаар сарын 25-ны дотор холбогдох системд шивж оруулсан байх.
- 2.3.14 Орон нутгийн төсвийн орлогын тооцооллыг энэхүү удирдамжид хавсаргасан [3\\_ОН төсвийн орлогын тооцоолол.xlsx](#) дагуу бэлтгэж, шаардлагатай мэдээллийг ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлээгүй тохиолдолд орлогын төсөөллийн Сангийн яаманд байгаа мэдээлэлд үндэслэн хянахыг анхаарна уу.

## 2.4 Орон нутгийн төсвийн зарлагын талаар

- 2.4.1 Төсвийн ерөнхийлөн захирагчийн харьяанд хамаарах сангуудын төлөвлөлт, хэрэгжилтийг “Төсвийн тухай хууль” болон “Засгийн газрын тусгай сангийн тухай хууль”-д тус тус нийцүүлэн төлөвлөж хуулийн хэрэгжилтийг ханган ажиллах. Тухайлбал, “Байгаль хамгаалах сан”, “Эрсдэлээс хамгаалах сан” зэрэг тодорхой хуулийн зохицуулалтгүй сангуудыг тусдаа дансанд төсөвлөхгүй байх.
- 2.4.2 Аймаг/нийслэлийн болон сум/дүүргийн ИТХ-ын тогтоолын 1 дүгээр хавсралтаар зөвхөн аймгийн эсвэл сумын төсвөөр хэрэгжүүлэх хөтөлбөр, хүрэх үр дүнгийн талаарх чанарын болон тоо хэмжээний үзүүлэлтийг батлах /сумын төсвийн суурь зарлага, суманд олгож байгаа орлогын шилжүүлэг санхүүгийн дэмжлэгийг оруулахгүй байх/;
- 2.4.3 Сангийн сайдын 2021 оны 204 дугаар тушаалаар аймаг /нийслэл, сум/дүүргийн ИТХ-ын Тогтоолын хавсралт №1 маягыг төвийн удирдамжаар хүргүүлж байгаа ТМ-01а- тай уялдуулах;
- 2.4.4 Төсвийн тухай хуулийн 31.1” эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх.” заалтын дагуу орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээ бүрийг үндсэн чиг үүрэгт хамаарах төсвийн хөтөлбөрөөр төлөвлөх;
- 2.4.5 Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-т заасан хувь, хэмжээний доод хязгаараас багагүй байхаар тооцож ирүүлэх;
- 2.4.6 Fiscal-д төсвийг оруулахдаа урсгал болон хөрөнгийн зардлыг үр дүн нь хамаарах хөтөлбөрийн ангиллыг зөв сонгож оруулах ба төсвийн зарлагын ангиллын “Ангилалдаагүй бусад” гэсэн хэсгийг сонгож оруулахгүй байх;
- 2.4.7 Дорноговь аймгийн сонгогдсон хөтөлбөрийн хүрээнд туршиж байгаа Тогтвортой хөгжлийн зорилтод нийцсэн үр дүнд суурилсан төсвийн төлөвлөлтийн маягт болон түүний зааварчилгааг [6.3\\_ҮДСТ Төсвийн саналын маягт\\_ОН.xlsx](#) болон [6.4\\_ҮДСТ Төсвийн саналын маягтын заавар\\_ОН.docx](#) дагуу бөглөх.

## **2.5 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний санал бэлтгэх**

Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийг үндэслэн улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төлөвлөгөөний төслийг 2023 оны 8 дугаар сарын 15-ны дотор албан тоотоор болон цахим системээр хүлээн авна.

Төсвийн Ерөнхийлөн захирагчид хөрөнгө оруулалтын төслийн саналаа бэлтгэхдээ цахим системд заасан үзүүлэлтийг бүрэн бөглөж, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцах бөгөөд энэ удирдамжид заасан шаардлагуудыг хангахгүй, холбогдох материалууд дутуу төсөл, арга хэмжээг хүлээн авахгүй, албан бичгээр буцаахыг анхаарна уу.

Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний төсөл нь дараах шаардлагыг хангасан байна:

- 2.5.1 Төсвийн тухай хуулийн 6, 27, 28, 29, 291 болон 31 дүгээр зүйл, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 20 дугаар зүйл, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 8, 11 дүгээр зүйл, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах” журам, 2018 оны 295 дугаар тушаалаар батлагдсан “Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийг үнэлэх, эрэмбэлэх, сонгох үйл ажиллагааны журам болон аргачлалууд”-ын дагуу төлөвлөж, улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим систем [www.publicinvestment.gov.mn](http://www.publicinvestment.gov.mn) болон албан бичгээр ирүүлэх;
- 2.5.2 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 2024 онд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа төсөл, арга хэмжээ нь Хөгжлийн бодлого, төлөвлөлт түүний удирдлагын тухай хуулийн дагуу улсын богино, дунд, урт хугацааны бодлогын баримт бичгүүдтэй уялдаж, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд батлагдсан байх, тэдгээрийн зорилтыг хангахад чиглэсэн байх;
- 2.5.3 Сангийн сайдын 2018 оны 295 дугаар тушаалын дагуу, улсын төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын цахим системээр дараах байдлаар төслүүдийг төлөвлөнө:
  - 2.5.3.1 Хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн аргачлалын дагуу Сангийн яамнаас цахим системээр хүргүүлсэн эхний шатны үнэлгээний шаардлага хангасан шинээр хэрэгжүүлэх төслүүдэд 2 дахь үе шат буюу сонгох шатны үнэлгээг хийх;
  - 2.5.3.2 Он дамжин хэрэгжих төслүүдэд дахин үнэлэх аргачлалын дагуу үнэлгээ хийх;
  - 2.5.3.3 Салбарын болон төслүүдийн танилцуулга, мэдээлэл, судалгааг ирүүлэх;
- 2.5.4 Төсвийн тухай хуулийн 14.2 дахь заалтын дагуу өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тухайн төсөв хэрэгжих жил болон дунд хугацаанд хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын арга хэмжээг жилийн төсвийн хязгаарт багтаан санхүүжилтийн бүх төрлийн эх үүсвэртэй нь уялдуулан боловсруулах;

- 2.5.5 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.3.5 дахь заалтын дагуу шинээр эхлэх төсөл, арга хэмжээний нийт төсөвт өртгөөс 2024 онд санхүүжих дүн нь төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх хугацаанд тэнцүү хуваарилсан хэмжээнээс багагүй байх буюу 3 жилд багтаан санхүүжүүлж, дуусгахаар төлөвлөх;
- 2.5.6 Төсвийн тухай хуулийн 22 дугаар зүйл, Сангийн сайдын 2015 оны 7 дугаар, 2021 оны 190 дүгээр тушаалаар баталсан эдийн засгийн ангиллын дагуу төсөл, арга хэмжээг төлөвлөх;
- 2.5.7 Барилгын тухай хуулийн 15.2, 13.2 дахь, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13.3 дахь заалт, Төсвийн тухай хуулийн 29.4 дэх заалтын дагуу 2024 онд шинээр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь магадлалын ерөнхий дүгнэлтээр батлагдсан зураг төсөвтэй, газрын зөвшөөрөл гарсан байх, холбогдох материалыг цахим системд оруулсан байх;
- 2.5.8 Улсын төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд улсын хэмжээнд хэрэгжүүлэхээр батлагддаг төслүүдийн задаргаа, холбогдох материалыг ирүүлэх;
- 2.5.9 Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслүүдийн улсын төсвийн урсгал зардалд үзүүлэх нөлөөллийн тооцоо, төсөл хэрэгжсэнээр шинээр бий болох ажлын байрны судалгаа, эдийн засгийн үр ашиг, нийгмийн ач холбогдлын мэдээллийг 295 дугаар тушаалын дагуу хийж, цахим системд оруулсан байх;
- 2.5.10 Төсвийн тухай хуулийн 31.4 дэх заалтын дагуу нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдолгүй гэж тооцоолсон хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсвэл санхүүжилтийг бууруулах санал, тооцоог ирүүлэх;
- 2.5.11 Улсын болон салбарын бодлогын хүрээнд ач холбогдлоор нь эрэмбэлсэн байх;
- 2.5.12 Төсөл, арга хэмжээний нэр томъёо, байршил, хүчин чадал, хэмжих нэгж жигд, мөнгөн илэрхийллийг сая төгрөгөөр цахим системд оруулсан байх;
- 2.5.13 Концессын эргэн төлөлтийн санхүүжилтийг 2024 оноос тухайн салбарын асуудал эрхэлсэн Төсвийн Ерөнхийлөн Захирагчийн багцад тусгах тул Эдийн засгийн хөгжлийн яамтай тооцоо нийлж, эргэн төлөлтийн саналаа ирүүлэх;

## **2.6 Гадаадын зээл, тусламжийн санхүүжилтээр хэрэгжих төсөл арга хэмжээний санал бэлтгэх**

Төсвийн ерөнхийлөн захирагч нь 2024 оны гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн саналаа боловсруулахдаа Засгийн газраас баталсан зарлагын хязгаар болон дунд хугацаанд зээл, тусламжид баримталж байгаа бодлого, чиглэлийг удирдлага болгон, **НМ-09** маягтад заасны дагуу саналыг бэлтгэх бөгөөд төсөл нь дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:

- 2.6.1 Гадаадын зээл, тусламжаар 2024 онд хэрэгжих төслүүдийг төсөл тус бүрээр шилжих, дуусах болон шинэ төслийн ангиллаар гарган, танилцуулгын хамт ирүүлэх;
- 2.6.2 Төслийн зардлыг урсгал, хөрөнгийн болон эргэн төлөгдөх нөхцөлтэй зардлын ангилалд хуваарилан тусгах бөгөөд эдийн засгийн дэлгэрэнгүй ангиллын дагуу төсвийн төслийг бэлтгэх;
- 2.6.3 Санхүүжилтийн эх үүсвэр хэсэгт гадаадын зээл, тусламж, орон нутгийн төсөв болон улсын төсвийн эх үүсвэр зэрэг аль эх үүсвэрээр санхүүжихийг тодорхой болгох;
- 2.6.4 Зээл, тусламжийн төслийн Төсөл хэрэгжүүлэх нэгжийн зардлын саналыг 2.5.1-2.5.3-д заасны дагуу тусад нь тооцож гаргах;
- 2.6.5 Төслийн төлөвлөгөөний саналыг гэрээний үндсэн валют болон төгрөг гэсэн 2 дүнгээр боловсруулах ба үндсэн валютыг төгрөгт хөрвүүлсэн өдрийн ханшны мэдээллийг оруулсан байх;
- 2.6.6 Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн Монголын тал хариуцах хөрөнгийн болон урсгал зардлын саналыг энэ зааврын 2.5.1-2.5.3-д заасан мэдээллээр гаргах ба танилцуулга, талуудын байгуулсан гэрээний холбогдох заалтын мэдээллийг хавсаргаж ирүүлэх;
- 2.6.7 Гадаадын зээл, тусламжаар хэрэгжих төслийн Монголын тал хариуцах 2024 оны хөрөнгө оруулалтын ажлын хувьд зураг төсөв, магадлалаар батлагдсан эсэх мэдээллийг хавсаргаж ирүүлэх, шилжин хэрэгжиж буй төслийн хувьд төсөвт өртөг, урьд онуудад авсан санхүүжилтийн мэдээллийг өссөн дүнгээр гаргаж ирүүлэх;
- 2.6.8 Дамжуулан зээлийн гэрээтэй болон гэрээ хийгдэх төслийн зардлыг эргэн төлөгдөх нөхцөлтэй зардлын ангилалд тусган ирүүлэх ба холбогдох гэрээний хуулбарыг ирүүлэх;
- 2.6.9 Гадаадын зээл, тусламжаар 2023 онд хэрэгжиж байгаа төслүүдийн хүлээгдэж буй гүйцэтгэлийг ирүүлнэ. Энэ хүрээнд урсгал, хөрөнгө болон эргэн төлөгдөх зардлыг нийт дүнгээр гаргаж, төслийн үндсэн үйл ажиллагааны данс болон төсөл хэрэгжүүлэх нэгжийн данс тус бүрээр салган хүлээгдэж буй гүйцэтгэлийг тооцсон байна. Мөн төслийн хэрэгжилтийн явц байдал, 2023 оны хэрэгжилтэд учирсан асуудал, хүрсэн үр дүнгийн танилцуулгыг ирүүлнэ.

## **2.7 Төсвийн саналыг FISCAL-B программд оруулах**

Төсвийн төлөвлөлтийн үйл явцыг Сангийн яам Fiscal программаар дамжуулан авах ба 2024 оны төсвийн орлого /орлогын саналыг зөвхөн орон нутаг программаар илгээнэ/ болон зарлагын саналыг онлайнд суурилсан FISCAL-B хувилбарыг ашиглаж Сангийн яаманд ирүүлнэ. Системд өгөгдөл оруулах зааварчилгааг энэхүү удирдамжид хавсаргасан **7\_Fiscal-B гарын авлага.doc** файлаас харна уу. Программд өгөгдөл оруулахтай холбоотой тодруулгыг Сангийн яамны ТБТГ-ын зөвлөх Ш.Оюунбаатар [oyunbaatar@mof.gov.mn](mailto:oyunbaatar@mof.gov.mn), Г.Солонго [solongo\\_g@mof.gov.mn](mailto:solongo_g@mof.gov.mn) хаягаар болон 51-265753, 51-267350 утсаар лавлана уу.

## 2.8 Төсвийн ангиллыг ашиглах

Төсвийн зардлыг төлөвлөхдөө эдийн засгийн, хөтөлбөрийн болон зориулалт, арга хэмжээний ангиллыг 2015 оны Сангийн Сайдын 7-р тушаалаар батлагдсан “Төсвийн ангилал шинэчлэн батлах тухай”-ын дагуу боловсруулах бөгөөд төсвийн зардлын эдийн засгийн ангиллыг ашиглах зааврыг 2020 оны Сангийн сайдын 190-р тушаалаар баталсан “Заавар батлах тухай”-ыг баримтлан төлөвлөж ирүүлэх;

Төсвийн зардлыг төлөвлөхдөө Төсвийн захирагч бүр өөрийн эрхлэх асуудлын хүрээнд тохирох хөтөлбөр, түүний хүрэх үр дүн болон үр дүнг хэмжих шалгуур үзүүлэлтийн хамт төлөвлөн ирүүлнэ. Аливаа арга хэмжээний аль нэг эдийн засгийн ангилалд бөөн дүнгээр зардал төлөвлөхгүй байх, урьд нь бөөн дүнгээр төлөвлөсөн зардлыг зохих хөтөлбөр, арга хэмжээ-зориулалт, эдийн засгийн ангиллаар нь задалж төсөвт тусгах. Ингэснээр салбарын төсвийн төлөвлөлт, гүйцэтгэлд бодлогын дүн шинжилгээ хийх, бодит мэдээллийг бүртгэх, төлөвлөлт-гүйцэтгэлийн уялдаа хангагдана;

Хөтөлбөрийн болон арга хэмжээний ангиллын “Ангилалдаагүй бусад” гэсэн хэсгийг сонгож төсвийн санал оруулахгүй байх. Хэрэв уг ангилалд санал оруулсан бол төсвийн төсөлд хянаж, тусгахгүй бөгөөд төсвийн орлого, эх үүсвэрийн дутагдлаас шалтгаалж төлөвлөсөн зарлагын санхүүжилтийг хойшлуулах, зардлыг бууруулах, эсвэл төсөвт тодотгол хийж бууруулах тохиолдолд энэхүү ангилал нь ач холбогдлоороо хамгийн сүүлд эрэмбэлэгдэхийг анхаарах;

Орон нутгийн ТЕЗ нар Төсвийн тухай хуулийн 31.1” эрхлэх асуудлын хүрээнд хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгасан байх:” заалтын дагуу орон нутгийн хөрөнгө оруулалт, орон нутгийн хөгжлийн сан, замын сан, байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардлын эх үүсвэрээр хэрэгжих төсөл арга хэмжээ бүрийг үндсэн чиг үүрэгт хамаарах төсвийн хөтөлбөрөөр төлөвлөх;

Хөтөлбөрийн орон тооны мэдээллийг **ТМ-01** маягтын “Г” хэсэгт заасан ангиллаар төсвийн төлөвлөлтийн FISCAL программд оруулсны дагуу бэлтгэх;

**ТМ-01** үндсэн маягт болон нэмэлт маягт (**НМ-01-10**)-ууд нь зөвхөн ТЕЗ-ийн түвшинд хийгдэх боловсруулалтыг шаарддаг тул төсвийн удирдамж түүний маягтуудыг доод шатны төсвийн захирагчдад шууд хуулбарлан хүргүүлэхгүй байхыг анхаарна уу. Харин эдгээр маягтуудаар төсвийн санал бэлтгэхийн тулд шаардагдах мэдээллийг доод шатны төсвийн захирагчдаас авах (орон тооны судалгаа, тэтгэвэрт гарах хүмүүсийн судалгаа, байгууллагын төсвийн санал гэх мэт) нь зүйтэй.

## 2.9 Төсвийн санал хүлээн авч хянах

Улсын төсөв, НДС-ийн төсөв, ЭМДС-ийн төсөв болон орон нутгийн төсөвт хамаарах Төсвийн ерөнхийлөн захирагчийн төсвийн саналыг дор дурдсан

хугацаанд хянаж Засгийн газар болон Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхэд бэлтгэнэ.

Хүснэгт 1. Төсвийн төсөл бэлтгэх процесс

Хяналт болон төлөвлөлтийн процесс	Эхлэх болон дуусах хугацаа
Аймаг, нийслэлийн 2024 оны төсвийн суурь орлого, суурь зарлагын саналыг хянах	VIII/07- VIII/15
Улсын төсөв, НДС-ийн төсөв, ЭМДС-ийн төсвийн саналыг хүлээн авч хянах	VIII/15- IX/01
Жилийн төсвийн төсөлд инфляцын болон бусад бодлогын тохируулга хийх	IX/01- IX/10
Монгол Улсын 2024 оны төсвийн төсөл, Нийгмийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төсөл, Эрүүл мэндийн даатгалын сангийн 2024 оны төсвийн төслийг тус тус холбогдох бусад материалын хамт Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэхэд бэлтгэх	IX/10- IX/15
ТЕЗ нартай 2024 оны төсвийн төслийн талаар хэлэлцүүлэг хийж холбогдох тохируулгыг хийн, УИХ-д өргөн мэдүүлэхэд бэлтгэх	IX/15- IX/30

Төсвийн Ерөнхийлөн захирагчид төсвийн төслийн саналаа бэлтгэхдээ маягтад заасан үзүүлэлтийг бүрэн бөглөж, мэдээллийн үнэн зөв, бодит байдлыг Төсвийн тухай хуульд заасны дагуу хариуцах бөгөөд дээрх шаардлагуудыг хангахгүй, холбогдох материалууд дутуу төсөл, арга хэмжээг хүлээн авахгүй, албан бичгээр буцаахыг анхаарна уу.

Аймаг нийслэлийн төсвийн санал ирүүлэхдээ дараах хуваарийн дагуу хянуулна.

Төсвийн санал хүлээн авч хянах хугацаа	Аймаг/Нийслэл	
2023.08.07	Даваа	Баян-Өлгий, Увс, Ховд, Өмнөговь
2023.08.08	Мягмар	Баянхонгор, Говь-Алтай, Завхан, Дорноговь, Дархан-Уул
2023.08.09	Лхагва	Архангай, Өвөрхангай, Хөвсгөл, Орхон
2023.08.10	Пүрэв	Булган, Дорнод, Сэлэнгэ, Төв, Говь-Сүмбэр
2023.08.11	Баасан	Дундговь, Сүхбаатар, Хэнтий
2023.08.14	Даваа	Улаанбаатар

### 3. ТӨСВИЙН САНАЛЫН МАЯГТ БӨГЛӨХ ЗААВАР

#### 3.1 Төсвийн үндсэн маягт буюу ТМ-01

Төсвийн ерөнхийлөн захирагч төсвийн төслийн санал боловсруулахдаа төсвийн зарлагын хязгаар, дунд хугацаанд төсвийн зарлагад баримталж байгаа бодлого, чиглэлд нийцүүлэн төсвийг хэмнэлттэй, үр ашигтай төлөвлөх ба төсвийн бодит боломжит нөөцөөр тухайн салбарын зорилтыг хамгийн үр



дүнтэйгээр хангахыг чухалчилна. Удирдамжийн хавсралт файл 1.1\_Төсвийн саналын маягт.xls-ыг бөглөхдөө дараах зүйлсийг анхаарах. Үүнд:

- 3.1.1 Урсгал болон хөрөнгийн зардлыг үндсэн чиг үүрэгт хамаарах хөтөлбөрөөр тодорхойлсон байх;
- 3.1.2 Хөтөлбөрийн төсвийн саналыг **ТМ-01** маягтад заасны дагуу “А” зардлын эдийн засгийн ангиллаар; “Б” зардлын зориулалт-арга хэмжээгээр; “В” санхүүжүүлэх эх үүсвэрээр задалж дунд хугацаагаар буюу 1-ээс 6 дугаар баганаар харуулсан байх;
- 3.1.3 Бүх хэсгүүдийн өөрчлөлтийн харьцуулалтыг 7, 8, 9 дүгээр баганаар харуулсан байх;
- 3.1.4 Төсвийн төслийг тухайн төсвийн жилийн батлагдсан орлого, зарлагын хязгаарт багтаасан байх (**ТМ-01** маягтын 3 дугаар багана);
- 3.1.5 Хэрэв урьдчилан төсөөлөх, төлөвлөх боломжгүй, түүнчлэн УИХ болон Засгийн газраас төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн хязгаар баталснаас хойш үүссэн нөхцөл байдлын улмаас батлагдсан төсвийн хязгаараас давах, зайлшгүй авч үзэх шаардлагатай төсвийн саналтай бол тооцооны төслийг ТМ-01 маягтын 4 дүгээр баганад харуулах, ингэхдээ тайлбараа нэмэлтээр оруулах;
- 3.1.6 Хөтөлбөрийн хүрээнд ажиллах орон тооны мэдээллийг төрийн албан хаагчийн ангиллын дагуу маягт **ТМ-01** ийн “Г” хэсэгт заасны дагуу үнэн зөв гаргаж харуулах;
- 3.1.7 Хөтөлбөрийн хүрээнд үйл ажиллагаа явуулах төсөв захирагчийн (төсвийн байгууллагын) төсвийн мэдээллийг **ТМ-01** маягтын “Д” хэсэгт холбогдох баганаар тусгаж харуулсан байх;
- 3.1.8 Хөтөлбөрийн хүрээнд ирэх он болон түүний дараагийн хоёр жилд хэрэгжүүлэхээр төлөвлөж байгаа зорилтуудыг **ТМ-01** маягтын “Е” хэсэгт товч тодорхой тусгана.
- 3.1.9 Зардлын тойм – Зардлын дүн шинжилгээ: **ТМ-01** маягтын “Ё” хэсгийг бэлтгэхэд дэмжлэг болгох зорилгоор нэмэлт тайлбар оруулж байна. Тухайн ТЭЗ-ийн багцын хувьд дунд хугацаанд салбарын бодлогын гол тэргүүлэх чиглэл, хүрэх үр дүнг хангахын тулд салбарын бодлого юунд чиглэж байгаа (ө.х. төсвийн хөрөнгийг юунд голлон зарцуулахаар төлөвлөж байгаа) талаар тайлбарлаж бичнэ. Тухайн багцын төсвийн суурь түвшинд өөрчлөлт оруулсан бол тэр талаар мөн бичнэ. Тухайн ТЭЗ-ын төсөв ямар гол хөтөлбөр, арга хэмжээг хэрэгжүүлэхэд хуваарилагдаж буй талаар, мөн нийт зардлын хувьд эдийн засгийн зардлын зүйл болон шилжүүлгүүдэд хэрхэн хуваарилагдсан, гол онцлох зүйлсийг дурдаж, энэ нь ямар бодлогыг хэрэгжүүлэхтэй холбоотой болохыг тайлбарлана.

Үр дүнгийн үзүүлэлтийг хангахад нөлөө үзүүлж байгаа гол хүчин зүйлүүд тухайлбал, орон тоо, бусад гол орц /зардлын зүйлс/-ууд г.м. зүйлсийн талаар дурдаж, зарлага нь орон тооны хандлага, гүйцэтгэлтэй яаж уялдаж буйг тайлбарлана. Тодорхой зарлагын өсөлт анхаарал татах хэмжээнд хүртэл өөрчлөгдөж байгаа бол энэ



нь юунаас болж өөрчлөгдөж буйг орц болон бүтээгдэхүүний гүйцэтгэлтэй уялдуулж тайлбарлах. Зардалд гол нөлөө үзүүлж буй хүчин зүйлс /зардал чиглүүлэгчид/ болон зардал, гарц /бүтээгдэхүүн, үйлчилгээ/ болон хөтөлбөрийн хоорондын уялдааг, дүн шинжилгээний хамт танилцуулах. Энэ хэсгийг дунджаар 2 хуудаст багтаан бичвэл зохимжтой. Дээрх хөтөлбөр, үр дүнгийн танилцуулгыг бичихэд дараах зүйлсийг харгалзан үзэх:

- (a) Бодлогын тэргүүлэх чиглэлүүдийг хангахад дунд хугацаанд төсвийн зарцуулалт аль хөтөлбөр, бүтээгдэхүүнд голлон чиглэж буй талаар товч дурдах;
- (b) Тодорхой гарц /бүтээгдэхүүн, үйлчилгээ/ хангахад гол хөтөлбөр болон зарлагын чиг хандлага, хүний нөөц болон бусад орц хэрхэн хувь нэмэр оруулах талаар дурдах;
- (c) Засгийн газраас баталсан хязгаар нь гарцыг нийлүүлэхэд хэрхэн нөлөөлөх вэ, суурь түвшинд гарах өөрчлөлт, тэрхүү өөрчлөлт гарахад хүргэж буй хүчин зүйлийг тодорхойлж оруулах;
- (d) Тэргүүлэх чиглэлүүдтэй уялдуулан гол хөтөлбөр болон орцын хувьд хангалтгүй хэмжээний төсөв хуваарилагдсан шалтгааныг тайлбарлах, дутагдсан санхүүжилт гарцын үзүүлэлтэд ямар нөлөө үзүүлсэн болон үүнийг ирэх жилийн төсвийн хувьд хэрхэн засаж, залруулах талаар оруулах;
- (e) Хүний нөөцийн болон бусад томоохон орцуудын өсөлтийн хувьд гарч буй өөрчлөлтийг дунд хугацааны төсвийн хүрээнд тайлбарлах.

3.1.10 Төсвийн хязгаараас давсан саналын үндэслэл, тайлбар, нотолгоог **ТМ-01** маягтын “Ж” хэсэгт товч тодорхойлсон байх. Хязгаараас давсан хэсгийн санхүүжилтийг ямар эх үүсвэрээс шийдвэрлэх ба ингэхдээ маягтын “З” хэсэгтэй уялдсан байдлаар тодорхойлох;

3.1.11 Нийгэм, эдийн засгийн хувьд ач холбогдол бага гэж үзэж байгаа хөтөлбөр, төсөл, арга хэмжээг зогсоох, эсхүл санхүүжилтийг бууруулах саналтай бол, түүнчлэн санхүүжилтийг нь бууруулах болон зогсоох хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлтийг юунд зарцуулах тухай саналаа **ТМ-01** маягтын “З” хэсэгт товч тодорхойлсон байх.

## 3.2 Төсвийн үндсэн маягтын нэмэлт буюу ТМ-01а

Төсвийн ерөнхийлөн захирагч нарын хэрэгжүүлэх хөтөлбөр, хөтөлбөрийн хүрэх дүн, тэдгээрийн шалгуур үзүүлэлтийг тодорхойлсон байх. ТЭЗ нар хүрэх үр дүнг тодорхойлохдоо “Монгол Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөө”-нд тусгагдсан холбогдох хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт, түүний суурь болон зорилтот түвшнийг харгалзан үзнэ. Хэрэв “Монгол Улсын хөгжлийн 2024

оны төлөвлөгөө”-нд тухайн хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлт тусгагдаагүй бол хөтөлбөрийг хариуцсан бодлогын мэргэжилтэн нь Эдийн засаг хөгжлийн сайдын 2022 оны 12 сарын 28-ны өдөр А/167 тоот тушаалаар батлагдсан үр дүнд суурилсан “Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө боловсруулах аргачлал”-ын дагуу боловсруулан хөтөлбөрийн үр дүнгийн шалгуур үзүүлэлтийн суурь ба зорилтот түвшнийг батлагдсан төсвийн хязгаарт багтаан тооцож, тодорхойлно. Ингэхдээ нэг хөтөлбөрт 3-с дээшгүй үр дүнг тодорхойлохыг анхаарна уу.

Түүнчлэн үр дүн болон шалгуур үзүүлэлт тодорхойлох аргачлалыг [1.3\\_ТМ-01а маягт бөглөх заавар.docx](#) - аас танилцана уу.

### 3.3 Төсвийн удирдамжид дагалдсан төсвийн маягтуудын товчоо

Хүснэгт 2. Төсвийн саналын нэмэлт маягтууд

Маягтын нэр	Хүснэгтийн код	Маягт болон хүснэгтийн агуулга
1.1_Төсвийн Удирдамж		ТЕЗ нарын 2024 оны төсөв бэлтгэх удирдамж
1.2_Төсвийн саналын маягт	НМ-01	ТЕЗ-ийн харьяалах төсвийн байгууллагын өөрийн орлогын санал
	НМ-02	ТЕЗ-ийн төсвийн урсгал зарлагын саналын товчоо
	НМ-03	ТЕЗ-ийн эргэж төлөгдөх цэвэр зээлийн санал
	НМ-04	ТЕЗ-ийн шинээр ашиглалтад орох хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээтэй холбогдон гарах урсгал зардлын тооцоо
	НМ-05	ЭМД-ын шимтгэлийг нь төрөөс хариуцан төлөх иргэдийн тооцоо
	НМ-06 (ОН) НМ-06а (ОН) НМ-06 (УТ) НМ-06а (УТ)	Нийгмийн халамжийн хөтөлбөрт хамрагдагчдын судалгаа
	НМ-07 НМ-07а НМ-07б НМ-07в	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн тэтгэмжийн судалгаа
	НМ-08	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх мөнгөн тэтгэмж авах албан хаагчийн судалгаа
	НМ-09	ТЕЗ-ийн Гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн санал
	НМ-10 НМ-10а	ОН-ийн сонгуулийн үр дүнгээр ажлаас чөлөөлөгдсөн албан хаагчид олгох тэтгэмжийн судалгаа
1.3_ТМ-01а маягт бөглөх заавар		ТМ-01а маягтыг бөглөх заавар
1.4_ТХЗ үр дүн тодорхойлох заавар (БШУЯ)		Боловсролын салбарын үр дүн, түүний шалгуур үзүүлэлт тодорхойлох аргачлал
2.1_ҮДСДХТ Маягт		Эрүүл мэнд болон боловсролын салбарын үр дүнд суурилсан дунд хугацааны төсөв боловсруулах маягт

2.2_ҮДСДХТ Маягтын заавар	Эрүүл мэнд болон боловсролын салбарын үр дүнд суурилсан дунд хугацааны төсөв боловсруулах маягтын зааварчилгаа
3_ОН-ын төсвийн орлогын тооцоолол	ОН-ын төсвийн орлогын тооцооллын маягт
4_Сум, дүүргийн суурь орлого, суурь зарлага	Сум, дүүргийн суурь орлого, суурь зарлагын маягт
5_ЖМТ асуулга ба төсвийн саналын маягт	Туршилтын яамдад зориулсан Жендэрийн мэдрэмжтэй төсөвлөлтийн төсвийн маягт
6.1_ҮДСТ төсвийн саналын маягт_УТ	Улсын төсвийн туршилтын яамдын ТХЗ холбогдсон үр дүнд суурилсан төсөвлөлтийн төсвийн маягт
6.2_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар_УТ	Улсын төсвийн туршилтын яамдын ТХЗ холбогдсон үр дүнд суурилсан төсөвлөлтийн төсвийн маягтын заавар
6.3_ҮДСТ төсвийн саналын маягт_ОН	Дорноговь аймгийн ТХЗ холбогдсон үр дүнд суурилсан төсөвлөлтийн төсвийн маягт
6.4_ҮДСТ төсвийн саналын маягтын заавар_ОН	Дорноговь аймгийн ТХЗ холбогдсон үр дүнд суурилсан төсөвлөлтийн төсвийн маягтын заавар
6.5_ҮДСТ Төсвийн шалгах хуудас	ТХЗ холбогдсон үр дүнд суурилсан төсөвлөлтийн маягтын шалгах хуудас
7_Fiscal-B гарын авлага	Fiscal – B гарын авлага

### 3.4 Бусад

- 3.4.1 Худалдан авах бараа, ажил, үйлчилгээний төлөвлөгөөний төслийг хавсаргасан байх;
- 3.4.2 Ажлын ачааллыг нягтруулах замаар одоо мөрдөгдөж байгаа орон тоог нэмэгдүүлэхгүй байх зарчим баримталж, орон тоо, цалингийн санг төлөвлөх;
- 3.4.3 Бараа үйлчилгээний үнийг хамгийн сүүлд эрх бүхий байгууллагаас баталсан тарифаар, төрийн албан хаагчийн цалин, тэтгэвэр тэтгэмжийн өсөлтийг тэгтэй тэнцүү байхаар тооцож ирүүлэх;
- 3.4.4 Олон улсын байгууллага, гадаад орны зээл, буцалтгүй тусламжийн хөрөнгөөр салбарын хэмжээнд хэрэгжиж буй болон хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ, хөтөлбөрийн орлого, зарлагын тооцоог нэмэлтээр хавсаргаж ирүүлэх;
- 3.4.5 Төсвийн байгууллагаас 2024 онд өндөр насны тэтгэвэрт гарахаар тооцсон хүмүүсийн тоог төсвийн төлөвлөлтийн Fiscal-B программд 80802 - Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг арга хэмжээ-зориулалтын ангилалд болон 46 кодтой **“НИЙТ ТЭТГЭВЭРТ ГАРАГЧ”** нэмэлт мэдээллийн ангиллыг тус тус сонгон оруулах;
- 3.4.6 Төрийн албан хаагчийн орон тооны мэдээллийг энэ удирдамжид хавсаргасан **7\_Fiscal-B гарын авлага.docx** -д заасны дагуу төсвийн төлөвлөлтийн **Fiscal-B системд** шивж оруулах;